



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А-189

Улаанбаатар хот

Үнэлгээний баг байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 4.1, 4.7 дахь заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан хаагчдын 2021 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх чиг үүрэг бүхий Үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Гантогтох

Гишүүд:

- Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун
- Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Батмөнх
- Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга В.Үнэнбат
- Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Чой-Иш
- Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Алтансүх
- Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Отгонцэцэг
- Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал
- Бодлого, төлөвлөлтийн газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Ганзориг
- Бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга Ж.Батсайхан
- Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Малын генетик, нөөцийн хэлтсийн дарга Д.Батсүрэн
- Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Д.Есөн-Эрдэнэ
- Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга О.Онон


00000748

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Ё.Мөнхтуяа
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Г.Мөнхмаргад

2. Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хууль, журамд нийцүүлэн дүгнэж, үнэлгээг 2021 оны 06 дугаар сарын 20-ны дотор багтаан танилцуулахыг Үнэлгээний баг /Т.Гантогтох/-т үүрэг болгосугай

ДАРГА



Т.ЖАМБАЛЦЭРЭН